

ДЭЛХИЙ

ОНЦЛОХ ХҮУДАС

АЛБАНИЙ ХҮНИЙ ҮГ

ЭНЭТХЭГ ТЕРРОРИЗМЫГ
ДЭМЖИГЧДЭД ХАРИУТ НЬ БАРИНА

IV нүүрт

Б.МӨНХДОРЖ: ААВЫН МИНЬ
МӨРӨӨДӨЛ ДРАМЫН ТЕАТРЫН
ТАЙЗНАА АМИЛНА

VI-VII нүүрт

Дугаарын 60 мөр

Хуурамч дуудлага
өгөгсдөд хатуу
хариуцлага тооцёё

Н.ПУНЦАГБОЛД

Эхлээд нэг тоо баримт дурьдая. Энэ оны эхний найман сарын байдлаар 101, 105 тусгай дугаарын утсанд нийт 130 гаруй мянган иргэн хандсан байна. Үүний 71 хувь нь хуурамч буюу хүүхэд тоглосон дуудлага, мэдээлэл байжээ. Энэ бол арай л хэтэрчихсэн тоо. Мөн 102 дугаарын утсанд 1.4 сая мэдээлэл ирснээс 19 хувь нь хуурамч дуудлага байсан аж. Харин 103 тусгай дугаарын утсанд 933 мянган дуудлага ирснээс 17 хувь нь тоглосон мэдээлэл иржээ. Гайхмаар тоо байгаа биз. 101, 105 бол гал түймэр, гамшиг осол, аврах ажиллагааны дуудлагын утас. Гэтэл энэ утсанд ирсэн 130 мянган дуудлагын 71 хувь нь буюу 90 гаруй мянга нь хуурамч байсан гэдэг чинь арай дэндэж байгаа биз дээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛЫН ТӨР “ТЭГ ЗОГСОЛТ” ХИЙЖ, НАМУУД ТАМИР СЭЛБЭНЭ

Ч.ЧУЛУУН

Дулааны цахилгаан станцууд жилд нэг удаа тэг зогсолт хийж, өвөлжилтийн бэлтгэлээ хангах нь бий. Хийхээр төлөвлөсөн засвараас шалтгаалан хугацаа нь адилгүй байдгийн дээр энэ тухайгаа холбогдох яам, тамгын газартаа мэдэгдэж, Эрчим хүчний диспетчерийн үндэсний төвөөс зөвшөөрөл авдаг дүрэм, журамтай. Өвлийн оргил ачааллын үед аль нэг станцид техникийн болон технологийн алдаа гарах аваас Монгол Улсын төв суурин газрууд хөлдөж, сүйд болно. Хохирлын хэмжээ саяар биш хэдэн арван их наядаар яригдана. Энэ бол эрчим хүчний салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудал. Чухамдаа эрчим

хүч ч үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол юм шүү дээ. Тиймээс урин дулаан цагийг ашиглаад жилд нэг удаа тэг зогсолт хийхийг нь зөвшөөрдөг. Иргэд ч ганц хоёр өдөр гэрэл цахилгаан, халуун хүйтэн усны хязгаарлалтыг даваад гардаг. Харин Засгийн эрхийг барьж буй улс төрийн хүчинд “тэг зогсолт” хийх тухай асуудал байж боломгүй зүйл. МАН орон нутгийн сонгууль болох гэж буйтай холбогдуулан УИХ-ын үйл ажиллагааг түр завсарлуулж, Монголын парламентын түүхэнд гарч байгаагүй захирамжийг гаргах нь тэр. Өөрөөр хэлбэл, УИХ-ын намрын ээлжит чуулганыг сум, дүүргийн ИТХ-ын сонгууль хүртэл долоо хоног завсарлага аваад байна.

Үргэлжлэл нь III нүүрт



С.БАТБОЛД: АЗИ ЕВРОПЫГ ХОЛБОСОН ХАМГИЙН ДӨТ ЗАМ НЬ МОНГОЛ УЛС

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар

Захиалгын үнэ 15600

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

Ж.ЭРДЭНЭБАТ VS Н.АЛТАНХУЯГ 100 ХОНОГ

Ж.ОТГОН

УИХ дахь Ардчилсан намын бүлэг мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд бүлгийн дэд дарга Ж.Батзандан орон нутгийн сонгуультай холбоотой асуудлаар мэдээлэл өглөө. Энэ удаагийн мэдээллээр орон нутгийн сонгууль, мэргэжлийн Засгийн газрын 100 хоног, Хамтын тэтгэвэрийн хуулийн асуудлаар мэдээлэл өглөө.

Орон нутагт бүртгэлгүй иргэдийг санал хураалтад оролцуулахгүй...

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Ж.Батзандан орон нутгийн сонгуультай холбоотой асуудлаар мэдээлэл өглөө. Тэрбээр

“2016 оны орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах талаар АН-ын бүлгээс ажлын хэсэг байгуулсан. Уг ажлын хэсэгт ирсэн хүсэлт гомдол, зөрчлийн талаарх саналуудыг Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн” гэв. Саналд зарим сум, дүүрэгт шүүхийн шийдвэр гараад байхад саналын хуудас хэвлэгдсэн гэх шалтгаанаар АН-аас нэр дэвшигчдийг бүртгэхгүй байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Ардчилсан намаас нэр дэвшигч Марений Төлөг, Байдиковын Аманкелди, Сагсай сумын Ардчилсан намаас нэр дэвшигч Торлахын Мурат, Меденханы Тилепберген, Ногооннуур сумын Ардчилсан намаас нэр дэвшигч Заводханы Серикбай нарыг бүртгээгүй юм байна.

Үргэлжлэл нь II нүүрт

PC mall. DELL ХААН БАНК

ЛИЗИНГИЙН ХҮҮ: ЖИЛИЙН 8% БОЛМОО

ЗӨВХӨН DELL БРЭНДИЙН НӨҮТБҮҮК

7575-3535 www.pcmall.mn /PCmallOfficial

ХААН банк			Худалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2266.00	2283.00	ФУНТ	2740.00	2841.00
ЕВРО	2475.00	2545.00	РУБЛЬ	34.80	37.90
ИЕН	21.69	22.29	ЮАНЬ	337.00	341.60

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2266.00	2283.00	ФУНТ	2754.00	2841.00
ЕВРО	2479.00	2557.00	РУБЛЬ	35.13	38.42
ИЕН	21.61	22.37	ЮАНЬ	337.00	341.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

VS

Ж.ЭРДЭНЭБАТ

Н.АЛТАНХУЯГ

100

ХОНОГ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Мөн хуулийн дагуу нэг иргэн нэглхэсэгт зөвхөн хурууныхээг таниулан санал өгөх боломжтой байлгах, сонгогчдын санал өгсөн эсэх байдлыг тэмдэглэхийг сануулжээ. Мөн хурууны тэмдэглэгээг ашиглах асуудлын хүрээнд 2016 оны зургадугаар сарын 27-ны өдөр УБЕГ, Статистикийн ерөнхий газрын дарга С.Мэндсайханы аймаг, дүүргийн сонгуулийн хороонд явуулсан 1/8196 албан тоотын дагуу 73 мянган иргэн хурууны хээ таниулахгүй зөвхөн иргэний үнэмлэхээр санал өгүүлсэн асуудлыг давтан гаргуулахгүй байхыг хүссэн байна. Өөр нэг зүйл нь санал хураалтын цаг дуустал санал хураалтын автомат машиныг сүлжээнээс салгах, санал хураалтын явцын дүн болон аливаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, тухайн орон нутагт бүртгэлгүй иргэдийг санал хураалтад оролцуулахгүй байх, тухайлбал хугацаат цэргийн албан хаагчдыг зохион байгуулалттайгаар санал өгүүлэх хууль бус ажиллагааг таслан зогсоох зэрэг асуудлуудыг судалж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэхийг хүссэн байна.

Г.Аким: Ахмадууд тэнэг хүмүүс биш, ойлгоно

Өмнөх парламентын баталсан Хамтын тэтгэврийн



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

тухай хуулийг шинэ парламент хүчингүй болгосон билээ. Тэгвэл тус хуулийг хүчингүй болгох нь үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж ахмадууд Үндсэн хуулийн Цэцэд ханджээ. Энэ талаар Үндсэн хуулийн Цэцэд хандсан ахмадуудыг төлөөлөн МУСГЗ, доктор, профессор, нэрт дуун хөрвүүлэгч Г.Аким “Хамтын тэтгэврийн тухай хууль баталсан нь олон хүнд тустай, амьдралд хэрэгтэй хууль болсон. Гэтэл шинэ Засгийн газар байгуулагдаад өмнөх парламентын баталсан сайн хуулийг цуцаллаа. Түүнийхээ оронд “Насны хишиг” өгөхөөр болж байгаа юм байна. Ахмадууд бид залуу насандаа улс эх орныхоо төлөө хийж, бүтээж, түүнээсээ татвар төлдөг байсан. Гэтэл ихэнх нь тэтгэврийн насанд хүрч чадалгүй, эс бол цөөн хэдэн жил тэтгэвэр аваад хорвоогийн мөнх бусыг үзүүлдэг. Хамтын тэтгэврийн тухай хуулиар тэтгэврээ авч чадахгүй хүмүүс ар, гэр, хань ижилдээ өвлүүлэн үлдээх боломжтой байсан.

Гэтэл энэ хуулийг хүчингүй болгож байгаа нь Үндсэн хуулийн гурван заалтыг зөрчиж байна гэж үзээд хэсэг ахмадууд Үндсэн хуулийн Цэцэд хандсан. Тодруулбал, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1-ийг зөрчсөн учраас Үндсэн хуулийн Цэцэд хандсан. Сонгуулийн үр дүнгээр төр засаг солигдох нь хамаагүй ганцхан төрийн залгамж чанартай, өмнөх засгийнхаа хийж хэрэгжүүлж байсан зөв, зүйтэй ажлыг үргэлжлүүлэх ёстой. Улстөрчдийн үл ойлголцол, залгамж чанаргүй байдлын золиос ард түмэн болох ёсгүй. Тэтгэвэр бол бидний насан туршдаа

хуримтлуулсан хувийн өмч. Энэ өмч хөрөнгийг өвлүүлэх эхний алхам нь Хамтын тэтгэврийн тухай хууль байсан. Үүнийг шинэ засаг гараад хүчингүй болгож болохгүй” гэсэн юм. Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болгож оронд нь “Насны хишиг” хөтөлбөрөөр 70-аас дээш насныханд улирал тутамд олгохоор болсон билээ. Энэ талаар тэрбээр “Одоо “Насны хишиг” гээд насаар нь ялгаварлаж олгох гэж байна. Уг нь Үндсэн хуульд нас, хүйсээр нь ялгаварлахгүй гэсэн байдаг биз дээ. 60-70 насныхан шоовдор, түүнээс хөгшин бол нэг хэдэн төгрөг өгөх нь л дээ. Өөрөөр хэлбэл, сардаа 10-20 мянган төгрөг өгөх л юм шиг байна. Тэгээд болоогүй “Насны хишиг” гэж нэрлээд байх юм. Гэтэл хишиг гэдэг үг чинь хүнд өөрөөсөө зүгээр бэлэг өгөхийг хэлдэг. Гэтэл МАН-ын өгөх гээд байгаа энэ мөнгө чинь бидний төрд зээлүүлсэн эргүүлээд авч байгаа хэлбэр. Харин эргүүлээд төлөхдөө хишиг хүртээж байна гэдэг маягаар өгч байгаа. Бодвол хишиг гэхээр л хөөрхий ахмадуудыг төр минь хишиг хүртээлээ гээд шогширно гэж ойлгосон байх. Бид чинь тэнэг хүмүүс биш, ойлгоно” хэмээсэн юм.

МАН–ынхан төрийн албыг наймааны хэрэгсэл болголоо гэв

УИХ дахь АН-ын бүлэг 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд бүрдсэн МАН-ын Мэргэжлийн гэх тодотголтой Засгийн газрыг ураг төрөл, хамаатан садан, уяачдын, давхардээлтэй мэргэжлийн бус

Засгийн газар байгуулагдсан МАН-ын Засгийн газрын 100 хэмээн дүгнэжээ. Тиймээс хоногт албан ёсны дүгнэлт

ШИНЭЧЛЭЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР 100 ХОНОГТ <i>/Ардчилсан нал - 2012 он/</i>	МЭРГЭЖЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР 100 ХОНОГТ <i>/Монгол Ардын Нал - 2016 он/</i>
<i>Монгол Улсын 27 дахь Ерөнхий Сайд Н.Алтанхуягийн Шинэчлэлийн Засгийн газар 2012 оны найтдугаар сарын 20-ны өдөр бүрдсэн.</i>	<i>Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын Мэргэжлийн Засгийн газар 2016 оны долдугаар сарын 30-ны өдөр бүрдсэн.</i>
2012.10.02 Гадаадад сурах оюутны тэтгэлгийг нээлттэй явуулдаг болов.	2016.08.22 Гадаадад их дээд сургуульд сурах оюутны сургалтын тэтгэлгийг зогсоолоо. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагсдын тэтгэлгийг зогсоов. “Сайн оюутан” хариуцлага бий болгох хөтөлбөрийг зогсоосон.
2012.11.04 Хямд нүүрс худалдаалдаг “Нүүрс” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв. 1 тонн нь 200,000 төгрөгийн үнэтэй нүүрсийг иргэдэд 80,000 төгрөгөөр хүргэдэг болсон.	2016.08.22 “Сайн хашаа” хөтөлбөр, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг зогсоосон.
2013.01.12 Малчдын хоршоог хөгжүүлэх талаар зарим хөлийн албан татварыг шинээр буй болгохыг мэдээлэв.	2016.08.22 “Сайн малчин” хөтөлбөрийг зогсоож, малын хөлийн албан татварыг шинээр буй болгохыг мэдээлэв.
2012.08.26 Засгийн газар бүрдээд зургаа дахь хоног дээрээ гаргасан шийдвэр нь Төрийн ордныг иргэдэд нээлттэй болгов.	2016.09.01 Засгийн газар бүрдээд 31 хоногийн дараа ах дүү, хамаатан садан, ураг төрлөө төрийн өндөр албан тушаалд томилж эхэлсэн. Одоо ч үргэлжилж байна.
2012.09.11 “Шинэчилж шийдье 222” төрийн ажилд иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулсан.	2016.09.01 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг зогсоов.
2012.09.21 Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл санаачилсан.	2016.09.07 Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болгов.
2012.10.12 Засгийн газар нүд чихээ нээж, иргэдээс мэдээлэл авах, санал гомдлыг хэрхэн шийдвэрлэснийг эргээд мэдэгдэх “11-11” төв ажиллаж эхэлсэн.	2016.09.12 “11-11” төвийг татан буулгалаа.
2012.09.03 Нийтийн алба 08:00 цагаас ажиллаж эхлэдэг болов.	2016.09.20 Төрийн албан хаагчдыг хоморголон халж эхлэв. -МАН-ын Засгийн газрын найман гишүүн “давхар дээлтэй” ажиллаж байна. -Дэд сайдын албан тушаалыг бий болгов. -Цалингийн татварыг нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа. -Эмч, багш нарын 36 сарын тэтгэмжийг бууруулав.
2012.09.19 Хүүхдэд архи, тамхи худалдаж, үйлчилбэл тусгай зөвшөөрлийг нь цуцлах шийдвэр гаргалаа.	2016.09.22 Архи, тамхины онцгой албан татварыг 20 хувиар нэмэгдүүлэх санал өргөн барив.
2012.11.17 Засгийн газраас 2015 он гэхэд 21 аймгийн төвийг хатуу хучилттай авто замаар холбох шийдвэр гаргасан.	2016.09.22 Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг бууруулав.
2012.10.22 Халамж хүүхэд рүү чиглэж орон даяар хүүхдийн мөнгө олгож эхлэв.	2016.09.26 Хүүхэд бүрт олгодог хүүхдийн мөнгийг ялгавартай өгөхөөр болов. Хүүхэд хамгаалын тухай хуулийн хэрэгжилтийг хойшлуулав.
2012.11.13 Хууль зүйн шинэчлэл эрчимжив.	2016.09.29 Эрүүгийн хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулав. - Зөрчлийн тухай хуулийг буцаасан.
2012.11.03 “Үйлдвэржилтийн шинэ эрин үе” зарласныг дэмжих тухай Засгийн газрын тогтоолыг батлав. /Шинэ төрлийн үйлдвэрүүдийг хөгжүүлж иргэдэд ажлын байр бий болгохыг уг тогтоолд чухалчлав./	2016.09.29 Шинэ төрлийн татварууд бий болгохоо мэдэгдэж, 2017 оноос хэрэгжүүлэхээр ярьж түр хойшлуулсан. / Орон сууцны шинэ татвар бий болгоно -Суудлын автомашины татвар нэмэгдэнэ -Цалингийн татвар төлнө -ХАОАТ-ыг нэмнэ -Ашигт малтмалын татварыг өсгөнө -Аж ахуй нэгж орлогын албан татварыг нэмэгдүүлнэ гэв./

Нийслэлийн хуулийг шинэчилэх нь

Нийслэлийн Засаг дарга С.Батболд өчигдөр Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад өргөн барилаа. Улаанбаатар хотод эдүгээ 1.5 сая иргэн оршин суудаг, аж ахуйн нэгжүүдийн 68 хувь нь төвлөрсөн, үндэсний нийт бүтээгдэхүүний 64.5 хувийг үйлдвэрлэдэг хот болж өргөжсөн байна. Үүнийг 22 жилийн өмнө УИХ-аар баталж байсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах боломжгүй

болсон төдийгүй, хөгжлийн шинэ орчиндоо тохирсон эрх зүйг шинээр бий болгох шаардлагатай холбоотойгоор дээрх хуулийн төслийг боловсруулсан байна. Ингэхдээ УИХ-аас өнгөрсөн жил баталсан Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уясан гэдгийг хотын дарга С.Батболд энэ үеэр мэдэгдлээ. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг шинэчлэн баталснаар дараах үр дүн дагуулах аж. Тодруулбал, Хот эрх зүйн хувьд бүх асуудлаа бие даан зохицуулах

боломж бүрдэнэ. Улаанбаатар хот засаг захиргааны хувьд цоо шинэ статустай болно. Мөн нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн хүн ам 300 мянгад хүрсэн байтал статусыг нь 2000 хүн амтай сумын төвшинд авч үздэг. Энэхүү газар, тэнгэр шиг зөрүү арилснаар нийслэлийн иргэд аймагтай дүйцэхүйц үйлчилгээг авах эрх зүйн орчин бүрдэнэ. Нийслэлийн Засаг даргаас эхлээд иргэн, аж ахуй нэгж бүгд хариуцлагатай байх тогтолцоо бий болно.

ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



С.БАТБОЛД: АЗИ ЕВРОПЫГ ХОЛБОСОН ХАМГИЙН ДӨТ ЗАМ НЬ МОНГОЛ УЛС

Н.ЗАЯА

Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Батболдтой тээврийн талаар ярилцлаа.

“Гурван улсыг холбосон транзит тээврийн туршилт өнгөрсөн наймдугаар сард амжилттай болсон. Транзит тээврийн үйл ажиллагаа хэзээ эхлэх вэ?”

“Эдийн засгийн хувьд харилцан нээлттэй байж, бие биеийн хөгжлийн стратегийг уялдуулж, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гурван талын хамтын ажиллагааны үндэс суурийг бэхжүүлж хамтдаа хөгжих нь чухал гэж үзсэний үндсэндээргурванулсын төрийн тэргүүн нарын Монголын “Талын зам”, Хятадын “Торгоны зам”, Оросын “Евразийн эдийн засгийн коридор” байгуулах санаачилгын хүрээнд “Эдийн засгийн коридор байгуулах” хөтөлбөр 2016 онд батлагдаж, манай гурван улс зам, тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд идэвхтэй хамтран ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөрт зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний нэг нь “Азийн авто замын сүлжээгээр олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудал юм.

Дамжин өнгөрөх тээвэр буюу транзит тээврийг хамтарч хэрэгжүүлэх талаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ууд 2005 оноос эхлэн ярилцаж эхэлсэн байдаг.

2013 оны дөрөвдүгээр сарын 23-24 хооронд Тайландын Бангкок хотноо зохион байгуулагдсан Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын хоорондын хил дамнасан тээврийн семинарын үр дүнд эхний шатанд АН-4 авто замын чиглэлийг ерөнхий чиглэл болгож, Монгол, Хятад, Орос гурван улсыг дамнасан авто замын дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргасан.

Энэхүү зөвлөмжийн дагуу Монгол, Хятад, Орос гурван улсыг дамнасан автозамын дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчинг бүрдүүлэх анхдугаар зөвлөлдөх уулзалтыг НҮБ-ын ын Ази номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-

оос 2014 оны дөрөвдүгээр сард БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан.

Гурав дахь зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо 2015 оны есдүгээр сард зохион байгуулсан бөгөөд энэхүү уулзалтаар Монголын талаас АНЗ коридорыг мөн оруулах санал тавьсан.

“Азийнавтозамынсүлжээгээр олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг гурван улсын ажлын хэсэг үндсэндээ тохиролцсон бөгөөд энэ оны арванхоёрдугаар сард баталгаажуулахаар төлөвлөгдсөн.

Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд АН 3 коридорын дагуу туршилтын тээвэрлэлтийг зохион байгуулахаар тохиролцсоны дагуу 2016 оны наймдугаар сарын 13-26-ны өдрүүдэд Хятад Улсын Тяньжинь боомт - Монгол Улсын Улаанбаатар хот - Орос Улсын Улаан-Үүдхотын чиглэлд тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Туршилтын тээвэрлэлтийн үйл ажиллагааг гурван тал дүгнэн үзээд тус тусын дотоодын бэлтгэл ажлыг хаггах, цаашид шийдвэрлэх бусад асуудлуудыг ажлын хэсэг байгуулан шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

“Энэхүү хэлэлцээр байгуулагдсаны дараа тээвэрлэлт шууд эхэлнэ гэсэн үг үү?”

Хэлэлцээр байгуулагдсанаар шууд тээвэрлэлт эхлэхгүй. Гурван талын тохиролцсоноор дотоодын бэлтгэл ажлуудыг хангасны үндсэн дээр 2018 оны хоёрдугаар хагас жилээс тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтмолжуулахаар тохиролцсон.

Жишээ нь, хэлэлцээрээр тохиролцсон нэг коридор буюу АН4автозамыгхатуухучилттай болгох ажил хийгдэж байгаа бөгөөд 2018 оны гуравдугаар улиралд дуусах ёстой.

“Бидний нэн түрүүнд хийх ёстой зүйл бол бэлтгэл ажил байх нь. Бэлтгэл ажил эхэлсэн үү?”

Бэлтгэл ажил эхэлсэн. Одоогийн байдлаар жолооч нарыг бэлтгэх, замын нөхцөл байдлыг сайжруулах гэх мэт ажлыг эхлүүлээд байна.

Азийн хөгжлийн банктай хамтранУлаанбаатараасДархан чиглэлийн замын нөхцөл байдлыг сайжруулах, шинэчлэн засах төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Үүнээс гадна авто замын дагуух үйлчилгээний байгууламж бий болгох, үйлчилгээний байгууллагуудын

стандартыг боловсруулан батлуулан, загвар зураг төслийг боловсруулсан. Тухайн үйлчилгээний байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр концессынзүйлсийнжагсаалтад тусгуулсан, одоо хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Үүнийг сонирхсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хөрөнгө оруулан хамтран ажиллах боломжтой. Мөн жолоочийн ажил, амралтын дэглэмийг зохицуулах зөвлөмжийг боловсруулсан бөгөөд цаашид дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

“Манай улс транзит тээврийн үйлчилгээгээр дамжуулан эдийн засгийн уналтаас гарах боломжтой гэж мэргэжилтнүүд үзэж байгаа. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас олох ашгийн урьдчилсан таамаг дэвшүүлсэн байх. Эхний удаад хэдий хэмжээний ашиг олно гэж тооцоолсон бэ?”

Туршилтын тээвэр Тяньжин-Улаанбаатар-Улаан-Үд гэсэн маршрутын дагуу нийт 2000 гаруй км замыгдөрвөн өдөрт гурван улсын тээвэрчид туулсан. ОХУ-ын ажлын хэсгээс танилцуулж байсан нэг зүйл бол: энэ коридор бидэнд хамгийн хэрэгтэй дөт зам юм. Жишээ нь, Тяньжин боомтоос Манжуураар Улаан-Үд хүрэхэд 3600 км, мөн Тяньжин боомтоос Энэтхэгийн далай, Атлантын далайгаар дамжин 60 гаруй мянган км замыг 50 орчим өдөрт туулан явж байгаа тээвэрлэлт ч байна гэж.

Эндээс аливаа бараа бүтээгдэхүүнийг хурдан хугацаанд шуурхай хүргэж өгөх эрэлт хэрэгцээ байгаа нь харагдаж байгаа юм. Тиймээс бид гурван улсыг холбосон транзит тээврийн үйлчилгээг эхэлбэл Ази-Европыг холбосон хамгийн дөт тээвэрлэлтийн маршрут бий болгох боломжтой.

Дамжин өнгөрөх тээвэрлэлтээс эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар хийгдсэн судалгаанууд бий.

Монгол Улс далайд гарцгүй орны нэг бөгөөд эдгээр улс орнуудын оршин байгаа газар нутгаас үл хамааран тулгардаг нийтлэг нэг асуудал нь гадаад худалдааны хувьд хамгийн зардал багатай тээвэр болох далайн тээврээс хол учир тээврийн зардал өндөр байдаг.

Эдгээр улсуудын дийлэнх нь буурай хөгжилтэй оронд хамаарах бөгөөд дэд бүтцийн хөгжил сул, үйлдвэрлэлийн

хүчин чадал бага, дотоодын зах зээл нь жижиг, гадаад сөрөг нөлөөнд эмзэг, дэлхийн зах зээлийн төвүүдээс алслагдсан зэрэг нийтлэг шинжтэй.

Монгол Улс далайд гарцгүй ч газар зүйн байрлалын давуу талаа ашиглан тээвэр логистикийн сүлжээг оновчтой хөгжүүлснээр сул талаа нөхөх боломжтой.

Гадаад худалдаанаас үр ашиг олж чадахгүй байгаа хөгжиж буй орнуудын хувьд гол асуудал нь газар зүйн болоодхудалдааны хориг саад байдаг, мөн газар зүйн байрлал, худалдаа эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх нөлөөллийн талаар судлаачид авч үзэх болсон. Энэ чиглэлийн судалгаанд далайд гарцгүй орнуудын худалдаа далайд гарцтай орнуудаас дунджаар 30 хувиар доогуур

байдаг гэж дүгнэсэн байна.

Далайд гарцгүй орнуудын логистикийн чадавхи нь өөрийн орны болоод дамжин өнгөрч буй далайд гарцтай, хөрш буюу транзит орны логистикийн системээс хамаарч байдаг. Манай улс далайд гарцгүй манай орны хувьд логистикийн чадвхи харьцангуй доогуур байгаа хэдий ч гадаад худалдааны голлох түнш, хөрш орон БНХАУ нь логистикийн чадавхийн нөлөөллийг ашиглан хөгжүүлэх боломжтой гэж үздэг.

Далайд гарцгүй орнуудын хувьд гадаад худалдааны нөхцөлөө сайжруулах, транзит орноос хараат байдлаа бууруулах, тээвэр логистикийн оновчтой хөгжүүлэх, хоёр талт болон бүс нутаг, олон талт гадаад худалдааг чөлөөлөх тухай гэрээ хэлэлцээрүүд хийх зэрэг хүчин чармайлт нь гадаад худалдаанаас олох үр ашгийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Далайд гарцтай болох боломж бий гэлээ. Манай улс Сингапур улсад өөрийн

хийх сонирхол бий. 2015 онд Монгол, Солонгосын хамтарсан тээврийн компани байгуулагдсан. Одоогийн байдлаар ОХУ, БНСУ зэрэг улсуудад далайн тээврийн мэргэжилтэн бэлтгэж байна.

“Салбар яамнаас олон улсын тээврийг хөгжүүлэхэд ямар бодлого барьж байна. Цаашид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг сонирхвол?”

Монгол Улс Автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хоёр талт хэлэлцээрийг есөн улстай, дамжин өнгөрөх тээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хоёр талт хэлэлцээрийг ОХУ, БНХАУ, БНКАЗУ-тай байгуулсан.

Цаашид тээвэрлэлтийн өсөн нэмэгдэж байгаа цар хүрээг харгалзан Герман, Польш, Чех улсуудтай хоёр талын хэлэлцээр байгуулах санал тавиад байна.

Аливаа томоохон төсөл, үйл ажиллагааг дагаж шинэ ажлын байр бий болдог. Тэр хэрээр хүмүүсийн

амьдрал дээшлэх нь бий. Гурван улсын тээврийн үйл ажиллагааг дагаж хэчнээн хүн ажлын байртай болох вэ?

Ажлын байрны тухайд одоогоор судалгааны ажил явагдаж байна. Гурван улсын эдийн засгийн коридортой холбогдуулан судалгааны хүрээлэн байгуулах тухай ярьж байна. Одоо бид нарийвчилж судлах шаардлагатай. Зөвхөн транзит тээвэр биш 2016-2020 оны хооронд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд улс хоорондын тээвэр, дамжин өнгөрөх тээвэр болон тээвэр ложистикийн төвүүд ашиглалтад орсноор авто тээврийн салбарт 7-10 мянган ажлын байр шинээр бий болох боломжтой гэж үзэж байгаа.

**ROYAL IRISH PUB**
7 жилийн ойн баяр

**ROYAL GRILL RESTAURANT**



ROYAL BEER FESTIVAL 2016
10.20-10.28 дуустал

Шинэ ургацын шар айраг Хамтлаг дуучдын тоглолт Сонирхолтой олон уралдаан тэмцээнүүд

Урилгаар

- Koln хамтлаг
- Гитар уйлуулагч Гантулга
- RecOn хамтлаг
- Madness хамтлаг
- Дуучин БоБо хамтлагтайгаа болон бусад хамтлаг дуучид, олон төрлийн сюрприз, сонирхолтой уралдаан тэмцээнүүд үдэш бүр таныг хүлээж байна.

Шинэ рестораны нээлтийн хямдралд БҮХ ХООЛ 7000₮ болон хямдарлаа.

ЗАХИАЛГА АВАХУТАГ 9903-4188



Хаяг: БЗД, 13-р хороолол, зүүн дөрвөн зам уруудаад Royal House зочид буудлын 1 давхарт ROYAL IRISH PUB



3-р хороолол Өргөө Номингийн хойморьт Роял хоус Зочид буудлын 2 давхарт ROYAL GRILL RESTAURANT

ХАМТРАВ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

ДЭЛХИЙ

Тайландчууд ЭМНЭЛЭГ САХИЖ ЭХЭЛЖЭЭ

Тайландчууд хааныхаа эрүүл мэндийн байдалд санаа зовнин, түүний хэвтэн эмчлүүлж буй “Сирираж” гэх эмнэлгийн гадна цугларч бурхандаа залбирч эхэлжээ. Тус улсын эзэн хаан Пумипон Адульядетын бие чилээрхсэн тухай мэдээлэл гарсны дараа тэд ийнхүү хурдан тэнхрээсэй хэмээн залбирах болсон байна. Хааны ордноос өнгөрөгч ням гарагт эзэн хааны биеийн байдалтай холбоотой мэдэгдэл хийж, хааны биеийн байдал тогтворгүй байгааг онцлон бүх ажлаа хойшлуулахыг эмч нар түүнд зөвлөсөн гэсэн юм. Түүнд нугасны илүүдэл шингэн авах эмчилгээ хийж, гемодиализын аппаратад оруулсны дараа цусны даралт нь буурч, улмаар амьсгалын аппарат зүүх хэмжээнд очтлоо биеийн байдал нь доройтсон байна. Эдүгээ 88 настай хаан энэ оны зургадугаар сард зүрхний хагалгаанд орж байжээ. Бангкок хотод хааны хэвтэж буй эмнэлгийн гадна олон хүн цуглаж, түүнийг хурдан тэнхрэхийн төлөө залбирч байгаа гэнэ. Түүнчлэн хүмүүс сүмд очин түүний төлөө залбирсаар байна. Эзэн хаан Пумипон Адульдет бол ядууралтай тэмцэх, хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн билээ. Мөн тэрбээр улс төрийн хямрал дэгдсэн хүнд үед улс орноо нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд эдүгээ улс орны эв нэгдэл, энх тайвны бэлгэдэл болж байгаа юм. Түүний хаан ширээнд заларсны 70 жилийн ой энэ онд тохиох бөгөөд тэрбээр хамгийн удаан хугацаанд сэнтийдээ заларсан хаан болж байгаа юм.

Хятадын тэрбумтан Парист дээрэмдүүллээ

Францын нийслэл Парис хотод амьдардаг Тайванийн тэрбумтан Шоу Лон Ванг гэгч 75 настай эмэгтэй өнгөрсөн долоо хоногт өөрийн гэртээ амарч байхдаа дээрэмдүүлжээ. Түүнд буу тулган дээрэмдсэн этгээдүүд 200 мянга хүртэлх евротой тэнцэхүйц үнэт эдлэлийг нь авч явсан байна. Шоу Лон Ванг Францын “Ланвин” загварын брэндийн гол хувьцаа эзэмшигчдийн нэг байжээ. Хэрэг энэ сарын 4-ний өдрийн үдээс хойш гарсан бөгөөд тэр үед эмэгтэй гэртээ унтаж байсан аж. Гэтэл хоёр этгээд халдаж, хуруундаа зүүж явсан бөгж, гар утас гэх мэт үнэт эдлэлийг нь булаан явсан байна. Азаар тэрбээр гэмтгэж бэртээгүй аж. Парист өмнө нь ч гэсэн ийм хэрэг гарч байсан удаатай. Реалиги шууны од Ким Кардашьян загварын долоо хоногт оролцохоор тус хотод ирээд байхад нь зүсээ хувилгасан хоёр этгээд мөн халдаж, есөн сая евротой тэнцэхүйц үнэ бүхий үнэт эдлэлийг нь дээрэмдэж байсан юм. Гэхдээ албаныхан дээрх хоёр хэрэг хоорондоо хамааралгүй гэж үзэж буй гэнэ.



ЭНЭТХЭГ ТЕРРОРИЗМЫГ ДЭМЖИГЧДЭД ХАРИУГ НЬ БАРИНА

...Энэтхэг, Пакистан хоёр улсын хооронд хилийн цэсийн асуудалтай холбоотой маргаантай байдаг Кашмирын бүс нутгийн Энэтхэгийн хяналтад байдаг Жамму Кашмирт алан хядагчид нэвтрэн 19 цэргийн алба хаагч амь үрэгдсэн юм...

Б.ДАВААХҮҮ

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модди Пакистаны хэт даврагч бүлэглэлийн этгээдүүд тус улсын хилийг зөрчиж, хэд хэдэн удаа мөргөлдөөн үүсгэсэн явдалтай холбогдуулан мэдэгдэл хийж, “Терроризмыг дэмжигчдэд өршөөл үзүүлэхгүй” хэмээн онцлон тэмдэглэлээ. Энэтхэгийн хойд этгээдэд орших Жамму Кашмирын бүс нутагт террористууд хяналтын бүсийг нэвтрэх оролдлогыг энэ он гарсаар 20 орчим удаа хийжээ. Улмаар Энэтхэгийн арми тухай бүрт илрүүлэн устгаж байсан аж. Тэгвэл өнгөрсөн сард Пакистаны хэт даврагчид мөн л Пуунч, Ури гэх хоёр газарт нэвтрэх оролдого хийн, мөргөлдөөн үүсгэсний

улмаас 19 цэрэг амиа алдсан байдаг. Харин үүний дараа Энэтхэгийн цэргийнхэн хөдөлж, Пакистаны нутаг дэвсгэр дэх террористуудын түшиц цэг рүү довтлон цэргийн ажиллагаа явуулж, долоон объектыг устгасан талаар албаны эх сурвалж мэдээлж байсан юм. Энэ үед ширүүн буудалцаан болон мөргөлдөөн үүссэн бөгөөд террористуудаас гадна Пакистаны армийнхан ч Энэтхэгийн эсрэг буу агссанаар хоёр улсын харилцаа хурцдаад байгаа билээ. Гэхдээ Энэтхэгийн талынхан байдлыг хурцатгахгүй гэх байр суурийг баримталж буйгаа онцолж, харин Пакистаны тал өөрсдийн газар шороо, нутаг дэвсгэрийг Энэтхэгийн эсрэг терроризмд

ашиглахыг үл зөвшөөрч, манай нутаг дэвсгэр рүү нэвтрэх, террорист үйл ажиллагаа явуулахгүй байна гэсэн 2004 оны нэгдүгээр сард гаргасан амлалтаа бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа нь сөргөлдөөнийг улам дэвэргэж байгааг шүүмжилж байсан билээ. Учир нь Энэтхэгийн цэргийн армийнханд олзлогдсон террористууд Пакистаны нутаг дэвсгэрт бэлтгэл, сургуулалт хийснээ хүлээсэн байгаа юм. Тэгвэл нөхцөл байдал хурцадсан энэ цаг үед Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модди мэдэгдэл хийлээ. Тэрбээр тус улсын хойд этгээдэд байрлах Лакхнау хотод ард иргэддээ хандан мэдэгдэл хийх үедээ “Терроризм бол хүн төрөлхтний дайсан. Энэтхэгийн ард түмэн бүгд

үүний эсрэг эвлэлдэн нэгдэж, терроризмыг бүхэлд нь устгах цаг иржээ” гэдгийг онцолжээ. Түүнчлэн, “Терроризмд оролцож буй хүмүүсийг бүгдийг нь устгах ёстой. Терроризмыг дэмжигчдийг ч өршөөж болохгүй” хэмээж, алан хядагчдыг бусармаг үйл ажиллагааг дэмжиж буй Пакистаны талыг хатуухан шүүмжилжээ. Энэтхэг, Пакистан хоёр улсын хооронд хилийн цэсийн асуудалтай холбоотой маргаантай байдаг Кашмирын бүс нутгийн Энэтхэгийн хяналтад байдаг Жамму Кашмирт алан хядагчид нэвтрэн 19 цэргийн алба хаагч амь үрэгдсэн юм. Үүнээс гадна зэвсэгт босогчид Застгийн газрын байр руу хууль бусаар нэвтрэсний улмаас тухайн хэсэгт буун дуу нүргэлсээр байна.

Трамп намынхаа гишүүдэд гомджээ

Эмэгтэйчүүдийг зүй бус үгээр гутаан доромжилсон бичлэг нь цацагдсаны улмаас олон нийтийн дунд хийгээд, нам нэгтнүүд нь ч нүүр буруулах болсон үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп твиттер хуудсаараа дамжуулан өөрөөс нь урвасан бүгд найрамдахчуудад анхааруулга өгөв. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшиж буй түүний “Алдартай байхад хүүхнүүдээр хүссэнээ хийлгэж болно” хэмээн эрээ цээргүй ярих бичлэг цахим сүлжээнд түймэр мэт хурдацтай тархсанаар түүний намын нөхөд нь ч дэмжихгүй гэдгээ илэрхийлж, сонгуулийн тулаанаас нэрээ татахыг уриалах болсон юм. Үүний улмаас Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтон дэмжигчдийнхээ хувиар олон

нийтийн судалгааг тэргүүлэх болсон билээ. Харин Доналд Трамп хоёр дахь удаагийн халз мэтгэлцээнийг өөрт ашигтайгаар эргүүлэхийн тулд тус мэтгэлцээнээс ердөө 90 минутын өмнө эхс Ерөнхийлөгч Билл Клинтонд хүчирхийлүүлсэн гэх эмэгтэйчүүдийн хамтаар хэвлэлийн хурал хийснээс гадна мэтгэлцээний үеэр ч, өрсөлдөгчийнхөө нөхрийн хормойн явдлыг сөхөж байлаа. Тухайн үед Трамп “Би зөвхөн үг хэлсэн. Харин Билл Клинтон үйлдлээрээ эмэгтэйчүүдийг гутаан доромжилсон. АНУ-ын улс төрийн түүхэнд түүнээс өөр ичгүүргүй хүн байхгүй” гэх утгатай үгийг амнаасаа унагасан бол Хиллари “Энэ үгээрээ Трамп өөрийгөө ямар хүн болохыг тов тодорхой харуулж байна” гэх үгээр амыг нь таглахыг хичээж байв. Тэгвэл ийм нөхцөл байдалд байгаа

Трамп саяхан хоёр цаг орчим твиттер сүлжээндээ идэвхитэй байж, энэ үеэрээ өөрөөс нь урвасан нэг намын нөхдөө тасралтгүй шүүмжилжээ. Тэрбээр “Хоёр дахь удаагийн халз мэтгэлцээний дараах олон нийтийн санал асуулгаар хөрсний гулгалт шиг л үр дүн гарлаа. Пол Райан нарын хүмүүс бүгдээрээ дэмжихгүй байхад бүхнийг сайн хийхийг оролдох үнэхээр хүнд байлаа” гэж жиргэсэн байна. Түүнчлэн, “Манай намын хамгийн сул удирдагч Пол Райан хөөрхий хурлын талаар ярилаа. Түүний итгэл эвдсэн үйлдлийг харсан намын гишүүд тэсэхгүй орилж байсан шүү. Цаашдаа ч би өөрийнхөө бодсоны дагуу АНУ-ын төлөө тэмцсээр байх болно” хэмээн үргэлжлүүлэн жиргэсээр байжээ.

БНАСАУ: НЭГДСЭН УЛСЫН ЭХ ГАЗАР ЦӨМИЙН ОВОО ХАРААНД ӨРТЛӨӨ

АНУ болон БНСУ-ын цэргийн хамтарсан сургуулилт энэ сарын 10-наас Солонгосын хойгт эхэлсэн. Жил бүр зохион байгуулагддаг уг цэргийн хамтарсан сургуулилтыг БНАСАУ-ын эсэргүүцэж, удаа дараа эсэргүүцлээ илэрхийлж байсан юм. Тэгвэл энэ онд ч мөн товлосон хугацаандаа эхэлсэн сургуулилтыг Пхеньяны тал эсэргүүцэж, “Солонгосын хойгийн байдлын хямралд хөтөлсөн өдөөн хатгалгын үйл ажиллагаа” хэмээн үзэж буйгаа мэдэгджээ. Энэ талаарх мэдэгдэл тус улсын төв хэвлэлийн өчигдрийн дугаарт хэвлэгдэн олон нийтэд хүрсэн байна. Мөн “Нэгдсэн улсын

эх газар цөмийн овоо хараанд өртлөө” хэмээн сүрдүүлээд амжжээ. АНУ, БНСУ-ын хамтарсан цэргийн сургуулилт энэ сарын 15-нд өндөрлөх бөгөөд эдгээр өдрүүдэд Солонгосын хойгийн баруун этгээд дэх шар тэнгис, Өмнөд Солонгос улсын харьяалалд багтах тэнгисийн орчмын бүс нутагт явагдаж байгаа аж. Сургуулилтад АНУ-ын цэргийн цөмийн зэвсэг тээгч онгоц гэх мэт 40 гаруй техник хэрэгсэл оролцож байна. Тэгвэл БНАСАУ-ын төв намын хэвлэлийн өчигдрийн дугаарт энэ удаагийн цэргийн сургуулилтыг эсэргүүцэж, хурцаар шүүмжилсэн нийтлэл хэвлэгджээ. Тэрхүү нийтлэлд



“Манай улс бодит байдал дээр цөмийн зэвсэг, стратегийн пуужинтай хүчирхэг орон бөгөөд Америкийн эх газар, номхон далайн байлдааны бүс нутгийн бүх бааз цөмийн зэвсгийн овоо хараанд орлоо” хэмээн сүрдүүлсэн байсан

ажээ. Энэ жилийн хоёр улсын цэргийн сургуулилт эхэлснээс хойш Пхеньяны талаас анх удаагаа хэвлэлээр дамжуулан эсэргүүцлээ илэрхийлж байгаа нь энэ юм. Сургуулилт эхэлсэн өдөр Хойд Солонгосын Хөдөлмөрийн

нам байгуулагдсаны ойтой давхацсан бөгөөд энэ үеэр ямар нэг эсэргүүцсэн мэдэгдлийг хийгээгүй байсан билээ. Гэхдээ зарим орнууд Хойд Солонгос улсыг дахин цөмийн зэвсэг туршихаар бэлтгэж байна хэмээн хардаж байсан юм.

ЧУХАЛ ХҮН

Н.БАТЗАЯА

Хаалга тасхийн дуугарч, гаднаас найруулагч Найдандорж “Миний ертөнцөөр” гэх шинэхэн номоо барьсаар орж ирэв. “Багш аа, хүү нь номоо гаргачихлаа. Тэгээд танд дээжээс нь барих гэсэн юм” гэсээр нөгөө л бидний сайн мэдэх бүрх талгайгаар гоёсон эрхэл бидний өнөөдрийн “Чухал хүн” булангийн маань хүндтэй зочин Б.Мөнхдорж гуайд номынхоо дээжийг өргөн барилаа. “Ямар сайхан ном бэ. Баярлалаа” гээд л өөрөө номоо гаргачихсан тэт баярлах аугаа найруулагчтай ийл л нэгэн уур амьсгал дунд хөөрөлдсөнөө хүргэе.

-УДЭТ-аас энэ сарыг түүхэн жүжгийн сар болгон зарласан. Тэр дундаа таны найруулсан “Харц хатан” дуулалт жүжиг олны дунд хүлээлт үүсгээд байна. Тиймээс ярилцлагаа энэ сэдвээс эхлэх үү?

-УДЭТ-аас энэ сарыг түүхэн жүжгийн сар болгон зарлаж, үзэгчиддээ бэлэг барьж байгаа юм. Тэдгээр жүжигт миний аав Бирваагийн хөгжмийг нь бичсэн “Харц хатан” дуулалт жүжиг багтсан. Энэ онд аавын минь мэндэлсний 100 жилийн ой тохиож буй. Ойн хүрээнд БСПУСЯ,Монголынхөгжмийн холбоо, Монголын урлагийн ажилтны холбоо хамтран олон ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Аав минь амьд сэрүүн ахуйдаа харц хатны домгоор жүжиг хийх юмсан гэж ярьдаг байж билээ. Тэр нь



Б.Мөнхдорж:

ААВЫН МИНЬ МӨРӨӨӨДӨЛ ДРАМЫН

ч учиртай. Домогт өгүүлэгдэх харц хатан нь эцгийн минь нутгийн бүсгүй байсан гэдэг. Иймээс л харц хатны домгоор жүжиг хийхийг хүсч, зорьсон болов уу. Харин 1985 онд миний эцгийн хүсэл биелж, Дорноговь аймгийн Саран хөхөө театрт хамгийн анх “Харц хатан” жүжиг тавигдсан. Аав хөгжмийн зохиолыг нь бичиж, Д.Төрбат гуай цомнолыг нь бичсэн юм. Тэд их гар нийлдэг, олон ч бүтээлд хамтарч ажилласан. Гэхдээ “Харц хатан” жүжигт тэднийг холбосон хүн нь миний шавь Э.Санчигдан байсан юм. Дорноговь аймгийн “Саран хөхөө” театрын Ерөнхий найруулагч байх үедээ аавыг урьж, хажуудаа суулгаж байгаад хөгжмийг нь бичүүлсэн гүүхтэй. Тэр үед аав жүжгийн хөгжмийг дуурийн хэмжээнд бичих хүсэлтэйгээ хэлж, “Харц хатан жүжгийн

арийг дуурийн хэмжээнд бичнэ. Танайд дуулах хүн хэн билээ” гэж асуусан байгаа юм. Харин Э.Санчигдан “Х.Нарантуяагаас өөр дуулах хүн байхгүй” гэсэн гэдэг. Ингэж л тэр жүжгийн гол дүрийг Х.Нарантуяа бүтээж, “Харц хатан” жүжиг театрын тайзнаа анх амилсан.

-“Харц хатан” жүжигт хайр дурлалын тухай өгүүлдэг. Хэзээ тавигдах вэ?

-Жүжгийн гол дүрийн хатан өрөвдөлтэй, эмгэнэлт хувь заяатай. Эцэстээ амьдаараа шатаж, нас бардаг. Тухайн үед ангийн үзэл сурталд үзэсгэлэнт бүсгүйг шулам гэгцээдэг байж. “Сайхан хүүхэн бүр шулам байдаг” гэх ойлголт ард иргэдийн дунд түгээмэл тархаж, хөөрхий бүсгүйг тогоонд шатааж, амийг нь хороосон эмгэнэлт түүхийг өгүүлдэг юм. Энэ бол бодит амьдралаас сэдэвлэсэн, түүхэн

домог. Харин тэрхүү домгоос сэдэвлэж, “Харц хатан” жүжиг төрсөн юм. Хожим аавыг тэнгэрийн оронд морилсны дараа жил нь дахин УДЭТ-ын тайзнаа тавьж билээ. Миний дүү Б.Мөнхболд хөгжим дээр нь ажиллаж, Х.Уртнасан гуай арийг нь дуулсан. Харин одоо “Харц хатан”-ны дүрийг жүжигчин Б.Эрдэнэцэцэг бүтээж байна. Жүжгийг түүхэн жүжгийн өдрүүд болон аавынхаа мэндэлсний 100 жилийн өйтой давхцуулан энэ сарын 15-нд ганцхан удаа л тоглоно.

-Дуулалт жүжгийн гол дүрийг драмын жүжигчин бүтээхэд асар их ур чадвар шаардагдах нь мэдээж. Жүжигчдээ сонгохдоо юуг чухалчилж, хэрхэн сонгов?

-Драмын жүжигчин ари дуулна гэдэг үнэндээ том асуудал. “Харц хатан”

ерөнхийдөө жижигхэн бэсрэг опера хэмжээний жүжиг шүү дээ. Тиймээс юун түрүүнд дуулалтыг нь чухалчилсан. Гол дүрд Ж.Оюундарь, Б.Эрдэнэцэцэг хоёр сайн өрсөлдсөн. Аль аль нь дуулалтдаа анхаарал хандуулж, өрсөлдөөн ч ширүүхэн байлаа. Манай жүжигчдийн дунд тийм сайхан өрсөлдөөн гарсан нь одоо ч миний сэтгэлд тод үлдсэн. Миний дүү Б.Мөнхболд хөгжмийн найруулгыг орчин цагийн өнгө аяст тааруулж шинэчлэн найруулж байгаа. Жүжигт хүний хайр сэтгэлийн тухай өгүүлнэ. Говь нутгийн хошуу ноёд сэтгэл алдарсан Сэржмядаг гэх үзэсгэлэнт бүсгүйн амьдрал, хувь заяа хаашаа эргэж хэрхэн төгссөнийг жүжгээр гаргаж ирэх юм. Түүнийг шатаасан тоогоо одоо ч Дорноговь аймагт бий. Ийм нэг эмгэнэлтэй

л хүсч байна. Өөрийнхөө чихийг, хоолойг сэргээхийг хүсч байгаа хэрэг. Концепц дээрээ ажилла, өөрсдийгөө бүх зүйлд бэлэн болгоорой гэж захимаар байна. Би “Харц хатан” жүжигт ажилласан бүх уран бүтээлчиддээ, театрынхаа хамт олонд баярлаж явдаг. Харамсалтай нь, жүжиг тайзнаа амилахыг хүсч, мөрөөдөж явсан ганц хүн нь үзэж чадсангүй. Аав бүр дуурь тавина гэж Л.Эрдэнэбулган найруулагч, Х.Уртнасан гуай хоёрт хэлсэн байдаг юм. Бид ч дуурийн хэмжээнд болгоё гэж хоорондоо ярьцгаасан. Гэхдээ дуурийн хэмжээнд очиж чадаагүй ч, ямар ч байсан дөхүүлээ. Дүү маань хөгжмийн зохиол дээр нь нарийн ажилласны үр дүнд хөгжимт жүжгийн хэлбэрээс нэлээд өөр хэлбэрт хүрсэн гэж бодож байна. Тиймээс жүжигчдийн ур чадварыг

ой, Драмын театрын 85 жилийн ой давхацсан энэ үед “Харц хатан” жүжгийг олон түмэнд хүргэх гэсэн хүсэл маань талаар өнгөрөхгүй байх. Ямартай ч, “Харц хатан” гэдэг дуулалт жүжиг тодорхой хэмжээнд драмын урлагийг хөгжмийн өндөрлөгт хүргэсэн бүтээл болно гэж ойлгож, итгэж байгаа.

-Бирваа гуайн мэндэлсний 100 жилийн ойг төрсөн нутагт нь тэмдэглэнэ гэж сонссон юм байна. Ойн хүрээнд ямар ямар үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн бэ?

-Миний аав Баянхонгор аймагт төрсөн. Тиймээс аавынхаа мэндэлсний 100 жилийн ойг Баянхонгор аймагт өргөн хүрээтэйгээр зохион байгуулна. Тэнд БСПУСЯ, Монголын хөгжмийн

МОНГОЛЫН АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨН, АРДЧИЛСАН НАМЫГ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИД БОЛОН СОНГОГЧ ИРГЭДДЭЭ ХАНДАЖ ГАРГАСАН УРИАЛГА

2016.10.07
Улаанбаатар

Монголын ардчилсан хөдөлгөөнүүд, Ардчилсан намыг үүсгэн байгуулагчдын анхдугаар зөвлөгөөнөөр “Монголын ардчиллыг үүсгэн байгуулагчдын холбоо” хэмээх нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага байгуулагдсаныг албан ёсоор зарлалаа. Тус байгууллага Ардчилсан хөдөлгөөн, Ардчилсан намыг үүсгэн байгуулагчдын эрх ашиг, ардчиллын үнэт зүйлсээ хамгаалах, АРДЧИЛШТЫН түүхэн ололтод үнэлэлт дүгнэлт өгөх, нэн тэргүүнд ардчилсан намыг шинэчлэх, улмаар “фракцигүй нэгдмэл нам” болох үйл хэрэгт хувь нэмэр оруулах эрхэм зорилгоо дэвшүүлэн ажиллаж байна.

Тус холбоо Ардчилсан нам шинэчлэгдэж “нэг үзэл бодол, нэг туган дор нэгдэн эв нэгдэлтэй байж – аажимдаа фракцигүй нам” болох нь намын жирийн гишүүд, дэмжигчид төдийгүй Монголын ард түмний хүлээлт мөн гэсэн улс төрийн дүгнэлт хийж байна.

Бид намын доторх аль нэг бүлэг фракцийн эрх

ашигт огт үйлчлэхгүй бөгөөд гагцхүү ардчилсан ёс, шударга ёсны төлөө ажиллах болно. Бид бүхний ажил зарим талаараа ойлголцолд хүрч, урагштай байгааг та бүхэнд уламжлахад таатай байна.

Монголын ард түмний өмнө өнөөгийн хамгийн тулгамдаж байгаа гол асуудал бол сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийг сонгох орон нутгийн сонгууль юм. Эрх баригчид болон МАН-аас нэр дэвшигчид хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэдтэй уулзалт хийхдээ: “Бид, Улсын их хурал, нийслэл аймгуудад ялалт байгууллаа. Одоо сум, дүүрэгт ялалт байгуулснаар улс орноо хөгжүүлж, ард түмнээ жаргуулах бололцоотой болно. Иймд МАН-аас нэр дэвшигчдэд 100 хувь саналаа өгөхийг “уриалах”, тулган шаардах боллоо. Тэд бүх шатны удирдлагыг гартаа авснаар бүх зүйл хяналтаас гарч, жинхэнэ дураараа дургихыг санаархаж байна. Тэдэнд Монголын ард түмэн хангалттай эрх мэдэл өгсөн, ажил хийж чаддаг л юм бол эрх мэдэл дутна гэж байхгүй.

МАН-ынхан Улсын их хурал, Засгийн газар, нийслэл аймгуудын эрх мэдлийг аваад 100 хоног өнгөрч байгаа боловч гарт баригдаж нүдэнд

харагдах юу ч хийгээгүйн дээр улс төрийн оновчтой ямар ч бодлого шийдвэр гаргаж чадсангүй.

Харин өмнөх Улсын их хурал, Засгийн газрын үед хийж бүтээсэн ажлуудыг харлуулж, гаргасан олон чухал шийдвэрүүдийг устгаж, тарааж, зогсоож шат шатны байгууллагад ажиллаж байсан олон арван хүнийг ажлаас халж, иргэдээ эдийн засгийн шинэ цагийн хэлмэгдүүлэлтэд өртүүлэн, 1924 оны анхдугаар Үндсэн хуулиар ангиар ялгаварлах үзлийг хуульчилсаныг өнөө цагийн нөхцөл байдлаар гүйцэтгүүлж, ялгаварлан гадуурхах үзлийг дэвэргэж, мөн тэдний оронд өөрсдийнхөө ах дүүс, танил тал, цүнх баригчдаа томилох ажлыг өдөр шөнөгүй хийж байна.

Иймд Ардчилсан хөдөлгөөн, Ардчилсан намыг үүсгэн байгуулагчид Та бүхэн!

Сум дүүргийнхээ иргэдийн төлөөлөгчдийн хуралд Ардчилсан намаас нэр дэвшигчдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэн, улмаар ялалт байгуулахыг УРИАЛЖ байна.

Сум, дүүргийн ИТХ-д Ардчилсан намын нэр дэвшигчид олонхи болсноор ард түмний аж амьдралын нөхцөл байдал болон ард иргэдийнхээ

үгний эрх баригчдад үнэн бодит байдлаар уламжлах, урьд бий болгосон бүтээн байгуулалт, өмнөх Засгийн газрын үед шинээр хийсэн бүх зүйл, эрх зүйн тогтолцоог хамгаалах улмаар ард түмний татварын мөнгийг “Ард түмэнд- сум, дүүрэг”-т хүргэж, зардал хэмнэх, хуримтлал бий болгох, зөв зохистой зарцуулах зэрэг эдийн засгийн үр нөлөөтэй олон чухал ач холбогдолтой ажил үйлсийг хийх бүрэн боломж байсаар байхад хэрэгжүүлэхгүй цаг алдсаар байна.

Ийнхүү Ардчилсан хөдөлгөөн, Ардчилсан намыг үүсгэн байгуулагч та бүхэн!

1990 оны Цагаан морин жилийн Ардчилсан хувьсгал, Ардчилсан намыг анх үүсгэн байгуулж байсан тэр эрч хүч, итгэл үнэмшлээрээ сум дүүрэг, аймаг нийслэлийн намын байгууллагуудтайгаа хамтран ажиллаж, орон нутгийн сонгуульд ялалт байгуулахыг УРИАЛЖ байна.

Сум, хороо, дүүрэг, аймаг нийслэлийн ардчилсан намын үүр хороодын удирдлагууд, Та бүхнийг Монголын ардчиллыг үүсгэн байгуулагчдад хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛЫН АРДЧИЛЛЫГ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧДЫН “ШУДАРГА ЁС” ХОЛБОО

ЧУХАА ХҮН

холбоо, Баянхонгор аймгийн нутгийн захиргаа, Засаг дарга хамтарч, авын дуунуудаар тэмцээн зохион байгуулах юм. Энэ санааг Баянхонгор аймгийн удирдлагууд өөрсдөө санаачилсан. Тэмцээн ойн анхны үйл ажиллагаа бөгөөд энэ сарын 22-24-нд болно. Тэмцээн нийтийн дуу, хүүхдийн дуу, мэргэжлийн дуу гэсэн гурван төрөлтэй. Гурван үе шаттай тэмцээнд хөгжмийн зохиолч, авын шавь П.Хаянхярваа, Ю.Самбуу нар их ач холбогдол өгсөн. Манай тэмцээнд гадаадын дуучид ч оролцохоо мэдэгдсэн. Тухайлбал, Улаан-Үд, Өвөрмонголоос дуучид ирж оролцох юм. Тэр утгаар нь олон улсын хэмжээний тэмцээн болох нь гэж дотроо баярлаж, сэтгэл их өндөр байгаа. Мөн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахаар төлөвлөсөн.

-Монголын ард түмэн Г.Бирваа гуайг хөгжмийн зохиолч гэдгээр нь илүү мэднэ. Эцэг хүнийхээ хувьд ямар хүн байсан бэ. Танд юу гэж захиж, сургадаг байв?

-Захиж, сургалгүй явах
вэ. Гэхдээ аав монгол ардын
уухаанар хүнтэй харьдаг
байсан. “Хүн эх орноо хайрлах
ёстой. Хүний хайрлаж явах
ёстой юм л тэр гэдэг. Тэр газар
нутагт унасан л бол чиний
юм. Тэнд чин зүрх сэтгэл уул
устайгаа хамт байх ёстой.
Төрсөн уул, ус, эх орныг хэн
өргдөг юм бэ гэвэл, эцэг эх чинь.
Надад үүнийг Гончиг гэдэг
хүн өгсөн. Гайхамшигт уртын
дуугаар хөглөж, нутаг орны
минь байгалийн сайхантай
танилцуулж, миний хөгжмийн
авьяасыг хөгжихөд, хөгжмийн
мэдрэх, түүний төлөө
амьдралаа зориулахад том
нөлөө үзүүлсэн. Уул, ус, хөгжим,
хөг аялгуу гэдэг нутаг ус, эх
орон байдаг юм” гэж аав минь
бидэнд хэлж, захидаг байсан.
Тиймээс аав анхныхаа номыг
“Эх орон гэдэг эцэг, эхээс
улбаатай” гэж нэрлэсэн байдаг

байна уу. Ийм аялгуу нийм байдаг юм” гээд л судална. Миний аав чинь амьдралын хар ухаан сайтай. Хөгжим, эх нутгийнх нь газар шороо, байгалийн зураг хөглөж, хүн ардад тэр лекцийнхээ утга учрыг сайхан тайлбарлаж өгдөг байсан. Тиймээс манай аав их сайхан лекц уншидаг байсан юм. “Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг”-ийн бүртгэл дээр тусгай лекцийн цагтай. Пүрэв гараг бүрт лекцээ тавьдаг. Тэгээд магнитофоноо бариад л явна шүү дээ. Лекц дээрээ аялгуу сонгож байгаад л ярина. Хурим, найрын дан аялгуу, ургын дууны тухай хязгааргүй ярина. Тэр бүхнийг холбож ярьдаг болохоор өөрийнх нь ертөнц өргөн хүрээтэй байсан байх. Тийм учраас аавын аялгуу, сэтгэлийн хөг, зүрхний учигууд нь эх

“дуулаасай” гэсэн үүднээс дээр дурьдсан тэмцээний болзолд оруулсан.

-Танай гэр бүлийнхэн урлагийн хүмүүс байдаг. Гэр бүлээрээ урлагтай холбогдох замыг магадгүй эцэг, эх тань нээсэн байх?

-Манай гэр бүлийнхэн бүгд урлагийн хүмүүс. Миний ээж Монгол Улсын циркийн хөгжимчин байлаа. Харин аав үүлээвэр хөгжимчин. Сүүлд нь Монгол Улсын филармонид байсан. Филармонийхоо дарга болоод удирдаачаар ажилласан. Миний урлагт орох зам хүүхэлдэйн театраас эхлэлтэй гэж болдог юм. Хүүхэлдэйн театр, цирк рүү би үүргэлж эцэг, эхээ дагаж явна. Тэгээд циркийн гоё үзүүлбэр, хөгжим, аялалгаг нарын тоглолт, хүүхэлдэйн театрын жүжигчдийн гарамгай

дээ. Яг тэр бүрээг нь миний дүү эзэмшиж, мэргэжлийн сургуулийг нь төгсч байлаа. Ер нь бүгд л хөгжмийнхөн. Б.Мөнхшүр Крузинд төгөлдөр хуурын анги төгссөн. Одоо багшилж байна даа.

-Та театрт анх хөл тавьж байсан үеэ дурсаач. Гэрийнхэн тань бүгд хөгжмийн урлагт шимтсэн байхад та яагаад театрт татагдах болов?

-Би Хүүхэддэйн театрт анх 1966 онд дагалдан жүжигчинээр орсон. Дараа нь 1969 онд сургуульд сурахуар явсан юм. Тэгээд л театрын амьдрал руу эргэлт буцалтгүй орсон хүн дээ. Мөн Монгол кино нэгтгэлтийн холбоотой. Яагаад гэвэл хамгийн анх урлагт хөл тавьсан газар маань Монгол кино нэгтгэл. Би 1965 онд “Түмний

хөгжмийн орчинд өссөн минь урлагтай амьдралаа холбоход нөөлөрсөн. Ээжийгээ дагаж явбал хөгжим сонсоно. Аавыгаа дагавал жүжиг үздэг. Тийм л байсан. Улсын филармонор би хөтлүүлээд л явж байсан. Одоо филармонийн ахмад хөгжимчид намайг мэднэ. Урлагийн ертөнц руу ойртоход хөтөч нь болсон хүн бол яах аргагүй миний ээж, аав хоёр. Тэгж байгаад л тэндээсээ өөрөө мулт үсрээд драм руу орчихсон болохоос биш.

-Урлаг танд ямар хүмүүжил олгосон бэ?

-Урлаг хүнийг өр нимгэн сэтгэлтэй болгодог гэж боддог. Зөөлөн, бүх зүйлд сайхангээлэг ханддаг. Аливаа зүйлийн гоё, сайхныг мэдэрдэг. Тухайлбал, гоё хөгжим, гоё дуунд татагддаг. Ямар ч байсан

чинь тэр үед 26-27 настай, том залуу байсан юм шүү дээ. Гэтэл ээжийн тэгж хэлэхийг сонсоод би уйлчихсан. Аав тэгсэн чинь “Нулимс гэдэг чинь хамаагүй газар гардаг зүйл биш. Нулимсыг хадгалж яв. Нулимс гарцаагүй урсаж байдаг зүйл ч биш. Хаана урсгах вэ гэдгээ хүн өөрөө олж авдаг юм. Чи жүжиг дээр хүнийг уйлуулах гэж байгаа бол уйлуул. Чиний жүжгийг үзэж байгаа хүн нулимсаа асгархуулахыг харвал би мэргэжлийн ажлаа сайн хийжээ гэж бод. Тэр цагт чиний найруулгын хэллэг хүнд хүрсэн байна гэсэн үг. Танай найруулгыг би мэдэхгүй” гэж хэлж билээ. Миний мэргэжлийн хамгийн эмзэг асуудлыг хэлчихсэн байгаа юм. Залуу байхдаа хүн уйлуулах, инээлүү гэсэн хоёр л зүйлд туйлширдаг



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ТЕАТРЫН ТАЙЗНАА АМИЛНА

юм билээ. Би анх намынх нь л ажил гэж ойлгодог байв. Залуу ч байж, юмны нарийн утгыг ойлгох гэж хичээдэггүй. Хэлсэн, ярьсан зүйлийг нь одоо ингээд бодохоор асар том зүйлийг сургасан байдаг. Бид л жижигхэн хүрээнд буулгаж “эх оронтой л холбоотой байдаг юм чинь” ухааны юм боддог байжээ. Гэтэл үнэн хэрэгтээ үгүй юм байна. Монгол жудаг, монгол ёс, монгол төрийн шүтэлцээ их учир утгатай, бас агуу. Миний аавын өөр нэг дүр төрх нь соён гэгээрүүлэгч байлаа. 1970-1980 онд “Монголын эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг” маш их хүчээ авсан. Тэр нийгэмлэгийнхэн хүмүүст лекц уншиж өгдөг. Манай аав ч лекц уншдаг. Гэхдээ ардын дуу хөгжим их сонсгоно. Янз бүрийн дуу чимээ хураана. Түүнийгээ мигнатофон дээр бичихээд “Энийг сонсож

орон, нутаг усандаа байжээ гэж би ойлгодог. Нутаг ус, эх орон, монгол түмэндээ хязгааргүй хайртай хүний нэг байсан. “Эх орон гэж яривал хүний сэтгэл бүх юм багтдаг юм. Ижий, аав ч багтана, Уул ус, гэр орон, та нар ч багтана” гэж хэлдэг. Залуу байхдаа “Би багтахдаа ч яах үе дээ” гэж боддог байлаа. Залуу насны тэнэг ойлголт л байхгүй юу. Тийм энгийн үгээр хэвшүүлж, оюун ухаанд минь суулгахыг хүссэн байгаа юм. Насны эцэст харахад би эх орон гэж ярихаас өөрийг хэлж чадахгүй болсон байна. Аав минь олон хүүхдийн дуунд ая зохиож, Монголын хүүхэд багачуудад хүргэсэн. Энэ нь ч учиртай. 1956 онд Хүүхэлдэйн театрт ажиллаж байсан юм. Хүүхэлдэйн жүжгийн дуу, хүүхдийн дуу их бичсэн. Аавын минь зохиосон олон гоё дуунууд бий. Энэ бүхнийг бид

сайхан тоглолт, цурхай загасны үлгэрийг хүүхдэд байхдаа их үздэг байлаа. Тэндээс мэдэрсэн сэтгэгдэл арга буюу намайг театрын ертөнцөд татса байх. Дүү нарын маань ихэнх нь хөгжмийн ертөнцөд хөл тавьсан. Ганцдүү маань ерөнхий эрдмийн судалгааны чиглэлээр суралцаж, МУИС-ийн хэл, уран зохиолын ангийг төгсөж, Монгол хэл, уран зохиолын судлаачаар ажилладаг. Одоо олон улсын байгууллагад ажиллаж байна. Манай дүү Б.Мөнхжаргал аавын тухай их юм ярина. Яагаад гэвэл манай гэр бүлийнхэн дундаа автайг хамгийн ойр байсан хэрэг л дээ. Б.Мөнхбаяр Улсын филармонийн Баянмонгол чуулгад бүрээчнээр ажиллаж байгаад тэтгэвэртнээ суусан. Аав минь анх цэргийн бүрээчнээр ажиллаж байхдаа Халх голын дайны бүрээг татсан хун шу

нэг” киноны хоёрдугаар ангид Жигжид гэдэг найруулагчийн ажилд сонирхлоороо тусалсан. Тэр үед кино жүжигчин болно гэж боддог байлаа. Гэхдээ болж чадаагүй. Бие жижигтэй, шүд байхгүй амьтан чинь яаж жүжигчин болох вэ дээ. Од л болох гэж бодсон шиг байгаа юм. Тэгж явсаар кино урлагийн, киноны ажлын зах зухыг мэдсэн. Дараа нь Б.Сумхүү, Р.Доржпалам гэдэг мундаг найруулагчдыг дагасан. Тунгэд буцаад театртаа ирсэн хүн дээ. Аав минь л энэ урлагт хөтөлсөн. Киноны хөгжим бичдэг байсан болохоор том кино найруулагчид манайд ирнэ. “Хөхөө гэрлэх дөхлөө.” “Нийслэл хүү”, “Аман хуур” гэх зэрэг кинонууд бүтээсэн Жамсран гэж сайхан кино найруулагч манайд их ирнэ. Бит тэр бүхнээ л найруулагчийн сайхныг олж харсан. Ер нь

миний сэтгэлийг зөөллөж
өгсөн. Миний дүү нар болон
надад энэрэнгүй, хүнлэг хандах
хандлагыг сургасан. Ингээд
бодоход, бидний сонголтгүйн
хөтөч нь миний эцэг эх хоёр
байжээ. Аав хүнд хүнлэг
сэтгэлээр хандах хамгийн
сайхан зүйл гэж дандаа хэлдэг
байж билээ. Гэхдээ өөрөө их
хатуу. Хуучуугаа шууд алгадаж,
зодож хэлнэ гэж байхгүй шүү
дээ. Чив чимээгүй байдаг
аймаар. Тэр байдал нь бүр ч
аймаар. Чив чимээгүй байхаас
хүн их айдгай байхгүй юу.

-Хүн нас ахих тусам ухаан нэмдэг гэдэг. Та нэг ярилцлагадаа аавдаа унатал алгадуулж байсан дурсамжаа хүваалцсан байж билээ?

-Би 1980-аад оны үед бор дарсанд хөлчүүрсэн. Тэр үед аав тэсэлгүй намайг нэг алгадсан юм. Тэгсэн ээж “хүүе хүүхэд аллаа” гэж байна. Би

байлаа. Гэтэл тийм биш юм. Хүний сэтгэлийн нарийн утсыг хаана харах вэ. Хөгжим, драмын урлагаас ялгаагүй харж болно. Энэ чадвар бидэнд байх ёстой. Бидэнд байх аваас бүтээл нь хүнд хүрнэ. Хүнд хүргэх гэж хүчээр юм хийвэл очдоггүй. Энэ бол манай мэргэжлийнхэнд, театрынханд хэлсэн миний эцгийн хамгийн том сургамж нь байлаа. Хүнийг уйлуулна гээд зүтгэвэл яагаад ч уйлахгүй, инээлгээ гээд зүтгэвэл бас л бүтэхгүй. Тэгэхээр тэр торгон мэдрэмжийн тухай л холуур хэлсэн хэрэг. Амьдралын асар буурь суурин дээрээс түүнийг олж харж хэлсэн байгаа юм. Түүнийг нь би залуу насандаа яаж мэдэх вэ дээ. Номоо бариад л зохиолоо тэгнэ, ингэнэ гээд шинжлэх ухааны юм яриад явж байсан. Энэ насны өндөрлөгөөс харж суухад их нарийн зүйлийг хэлж байжээ.



ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

“Бууж өгье”



Б.ДАВАА

Гараа өргөн бууж өгч буйгаа илтгэх энэ бяцхан жаалын зураг онлайн ертөнцөд хэдэн мянган удаа тарсан. Гэхдээ зургийн ард чухам ямар түүх өрнөнө вэ. Нүдэнд нь айдас хурсан хүүхдийн эл зураг “Өөр рүү нь чиглэсэн бууны өөдөөс гараа өргөн бууж өгч буй сири хүү” гэх тайлбартайгаар онлайнд цацагдаж байсан. Гэхдээ тэрхүү жаалын айсан зүйл нь буу байгаагүй, зүгээр л гэрэл зургийн камер байсан гэдэг. Туркийн

гэрэл зурагчин Осман Сагирли энэ зургийг 2014 онд авчээ. Зургийг өнгөц харахад эрэгтэй хүүхэд мэт харагдах хэдий ч, үнэн хэрэгтээ Худеа гэгч дөрвөн настай охин байсан гэнэ. Зургийг 2014 оны арванхоёрдугаар сард Туркийн хилийн ойролцоох Сирийн дүрвэгсдийн лагерьт авчээ. Охин ээж болон хоёр ахынхаа хамт тэнд амьдарч байсан бөгөөд тэд 150 км-ын алсад орших Хама дахь гэрээсээ дүрвэн энэ нутагт ирсэн байжээ. Гадаад ертөнцөд өрнөж буй дайн самуун, байгалийн

гамшигт үзэгдлийн чиглэлээр бүтээл туурвидаг гэрэл зурагчин эр 25 гаруй жилийн өмнөөс камертайгаа холбогдсон байна. Улмаар Сири иргэдийн лагерьт хүрэлцэн ирсэн тэрбээр аппаратныхаа линзийг гаргаж ирэх үед зураг дээрх охин тэсрэх бодис байна хэмээн айж байсныг нэгэнтээ дурссан удаатай. Залуу охины зургийг дарсныхаа дараа л хэрхэн айж мэгдсэнийг нь ойлгосон гэдэг. Түүнийг авсан зургаа гүйлгэн харах үед нь охин амаа жимийж, хоёр гараа өргөн, нүдэндээ айдастай зогсч

байжээ. Энэ зураг хамгийн анх 2014 оны нэгдүгээр сард Туркийн сонинд хэвлэгдэж, улмаар социал медиагаар цацагдан, дэлхий нийтэд тархжээ. Энх цагт амьдарч буй хүүхдүүд гэрэл зургийн камер харахдаа инээлдэн гүйж, элдэв поз аван зогсч, эсвэл нүүрээ нуун инээлддэг. Тэгвэл бидний хаягдсан эринийхэн хэмээн нэрлэдэг эмгэнэлт хувь заяатай сирийн бяцхан хүүхдүүдийн нэгэн агшин гэрэл зурагт ийн буужээ.

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр 16
Шөнө 1



Нөгөөдөр

Өдөр 9
Шөнө 3

Өдрийн зурхай

Намрын адаг шар нохой сарын Есөн улаан мэнгэтэй Шар луу өдөр. Бархасбадь гараг

Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шингэх: 07:12 - 18:19



Өдрийн өнгө: Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрлийг нолхотгох, гэмтнийг шийтгэх, мал адеуус нолхруулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг нолхотгох, хөгжлийн зэлсэг урлах, хур оруулах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад луу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахайболой. Хол газар яваар одогсод зүүн зүгт төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиролжгүй.

Бидэнд тохиолдсон



ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Nomin Galaа




Одоогоос 10 гаруй жилийн өмнө 10-р ангиа төгсөх гээд монгол хэлний улсын шалгалт өгөв. Тестэн дотор “Тунах үхрийн мах идээд цаддаггүй” юу ч билээ ямар ч байсан Хасарын тухай уран сайхны ниллэл байсан юм. Хариулт нь таван үсэг таарахаар дөрвөлжинтэй. Шалгалтын дүн ч гарлаа. Гэтэл монгол хэлний багш маань аймар ууртай орж ирлээ. “Монгол Улсын хэмжээнд ганцхан хүн “мангас” гэж бичсэн байна. Тэр эргүү амьтан босоод ир” гэж хэллээ. Харин тэгтэл манай ангийн нөхөр толгойгоо маажгаад босоод ирдэг юм. Таван нүдэнд нь “манга” гэж бичээд багтахгүй “с” үсгийг нь “а”-гийнх нь ард жижиг биччихсэн байдаг юм даа. Одоо хэр нь ангиараа уулзахдаа энэ явдлыг ярьж бөөн инээдэм болдог. Найз харж байгаа бол уучлаарай. Ха ха ха

ДУУЛГАХ СОНИН

“Бүргэдчин охин” кино ОСКАРТ өрсөлдөнө

Монгол Улсын нэр, Баян-Өлгий аймгийн зон олны аж амьдрал, ахуй соёлыг дэлхий дахинд түгээж чадсан бүргэдчин охин Н.Айшолпан “The Eagle Huntress” киноны гол дүрд тогросон билээ. Бяцхан биедээ багтамгүй эр зориг, тэсвэр тэвчээрийг гаргасан Н.Айшолпан охины нэр хүнд ч гараас нь дүүлэн ниссэн бүргэд адил Холливуд даяар алдаршсан. Н.Айшолпан охин Британийн BBC агентлагийн гэрэл зурагчны дуранд өртөж, баримтат киноны гол дүрийг бүтээсэн гэдэг. Тэгвэл тус баримтат кино Олон улсын Хэмптонсын кино наадамд түрүүлсэн тухай мэдээлэл цацагдаж эхэллээ. Тус наадамд түрүүлснээр “Бүргэдчин охин” кино Оскарын шилдэг гадаад киноны төрөлд нэр дэвших боломжтой болж байгаа юм байна.




Дижитал хамтлаг “ГАЛЗУУ ГАНЦ” тоглолтоо хийхээр болжээ

“Тандан буурахгүй”, “Чамдаа”, “Анддаа” зэрэг дуугаараа залуусыг байлдан дагуулсан “Дижитал” хамтлагийнхан “Галзуу ганц” тоглолтоо хийх гэж байна. Тэдний тоглолт энэ сарын 21-ний 19.00 цагт “Crocus event hall”-д болох бөгөөд тоглолтод “Ice Top”, “Мон Та Реп”, “Энх тайван”, “No name” хамтлаг болон рэптер Жий нар оролцож, өөрсдийн уран бүтээлээ хүргэх юм байна. “Галзуу ганц” тоглолтын тасалбар 15 мянган төгрөг бөгөөд тусгай тасалбар нь 20 мянган төгрөгийн үнэтэй. Мөн “Дижитал” хамтлагийн тоглолтын орлого “Хүн бүр сурах эрхтэй” сайн үйлсийн төсөлд хандивлагдах гэнэ.



ТЭНГИС
KING THEATRE

2016.10.13-НЫ ҮЗВЭРИЙН ХУВААРЬ

 18:00	 20:00	 22:25	 10:30 12:20 14:10 16:00 18:50 20:50 23:15vip	 11:00 13:00 14:50 16:50
 17:25vip 21:15 23:00	 10:30 13:00 14:40vip 15:30 18:00 20:40 23:20	 12:35 17:00 19:20vip 21:20vip	 10:30 12:35vip 14:45 19:05 22:50	 2016.10.14 ТҮН УДАХГҮЙ 2016.10.14